



Дээрх кодоос татаж авна уу.

# Шинэ төрлийн Корона вирусын эсрэг тусламжийн карт

Ашиглах зориулалт бүхий тусламжийн тогтолцооны картаа хайж олно уу.

※ Тус бүрийн тогтолцоонд мөрдөх/хэрэглэх нөхцөл, шаардлага болон нэмэлт төсөвт цаашид өөрчлөлт орох боломжтойг анхаарна уу. Иймд өөрчлөлтийн талаарх мэдээллийг холбогдох нүүр хуудсаас (QR код) авна уу.

Шинэ төрлийн Коронавирусын эсрэг тусламжийн карт © 2020 Өмгөөлөгч Нагано Кай

Мөнгө тэтгэмж, тусламж

## Бизнесийг тогтворжуулах мөнгөн тэтгэмж



Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч болон бусад аливаа хэлбэрийн хуулийн этгээд  
**Дээд хэмжээ: 2,000,000 иэн**  
 Хувиараа аж ахуй эрхлэгч  
**Дээд хэмжээ: 1,000,000 иэн**

## Харилцах цонх


0570-783-183

### Болзол

Шинэ төрлийн Корона вирусын улмаас энэ оны аль нэг сарын ашиг орлого нь өмнөх оны мөн сарын ашиг орлогын хэмжээнээс 50% болон түүнээс дээш хувиар буурсан аж ахуй эрхлэгч

Олгогдох тэтгэмжийн хэмжээ нь өмнөх оны нийт ашиг орлогын хэмжээтэй харьцуулан буурсан хэмжээгээр хязгаарлагдана

## Бага сургууль түр хаагдсаны улмаас хүүхэд чөлөөтэй үе дэх мөнгөн тэтгэмж



2 сарын 27-ны өдрөөс 6 сарын 30-ны өдрийн хоорондох хугацаанд гүйцэтгэхээр тохирсон ажлыг хийж чадаагүй өдөр  
**Нэг өдрийн 4,100 иэнээр тооцно**

## Харилцах цонх


Сургууль түр хаагдсан үе дэх мөнгөн тэтгэмжийн талаарх хүсэлт хүлээн авах төв

### Болзол

Сургууль түр хаах онцгой шийдвэрээс шалтгаалж хүүхэд харах шаардлагатай болж гэрээний дагуух ажил үйлчилгээг гүйцэтгэж чадаагүй асран хамгаалагч

Сургууль түр хаах онцгой шийдвэрээс өмнө байгуулсан ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээг хамруулна

## IT нэвтрүүлэхэд дэмжих мөнгөн тусламж (тусгай ангилал)



Тэтгэмжийн хувь **2/3**  
**Хэмжээ 300,000-с 4,500,000 иэн**

## Харилцах цонх

Үйлчилгээний дизайныг хөгжүүлэх зөвлөл

### Болзол

Гэрээс ажиллах Сургууль түр хаах онцгой шийдвэрийн улмаас хүүхэд харахаар чөлөө авсан асран хамгаалагчийн ажиллаж буй албан байгууллага

Компьютер болон таблет түрээслэх зардлыг нэхэмжлэх боломжтой

Бусад мөнгөн тэтгэмж

## Хөдөлмөрийн харилцааг дахин зохицуулах тэтгэмж (Онцгой арга хэмжээ)



Хувийн болон албан байгууллагаас хамаарах шалтгааны улмаас чөлөөтэй үе дэх төлөгдсөн тэтгэмжийн тодорхой хувь (Дээд тал нь 100%-р тооцохоор төлөвлөж байгаа) **(1 хүний өдрийн 8,330 иэн хүртэл)**

## Харилцах цонх


Хөдөлмөр хамгааллын байгууллага болон Hello work (ハローワーク)

### Болзол

Корона вирусын улмаас ажилтандаа **(цагын ажилтанг хамруулна)** чөлөөтэй үе дэх тэтгэмж төлсөн аж ахуй эрхлэгч

Онцгой арга хэмжээ нь 4 сарын 1-с 6 сарын 30 хүртэл хэрэгжинэ

## Бага сургууль түр хаагдсаны улмаас хүүхэд чөлөөтэй үе дэх мөнгөн тэтгэмж



Цалинтай ээлжийн амралтаа авсан ажилтанд төлөх цалин хөлсний тусламж **(1 хүнд өдрийн дээд хэмжээ нь 8,330 иен)**

## Харилцах цонх


Сургууль түр хаагдсан үе дэх мөнгөн тэтгэмжийн талаарх хүсэлт хүлээн авах төв

### Болзол

Сургууль түр хаах онцгой шийдвэрийн улмаас хүүхэд харахаар чөлөө авсан асран хамгаалагчийн ажиллаж буй албан байгууллага

2 сарын 27-ны өдрөөс 6 сарын 30-ны өдөр хүртэл хугацаанд хэрэгжинэ

## Бизнесийг тогтворжуулах мөнгөн тэтгэмж (Тусгай ангилал)



Тэтгэмжийн хувь **2/3**  
**Хэмжээ 1,000,000 иэн хүртэл**

## Харилцах цонх

Худалдаа, үйлдвэрлэлийн холбоодын нэгдсэн холбоо болон Японы худалдаа, үйлдвэрлэлийн танхим


### Болзол

Корона вирусын улмаас вэб сайтад суурилсан худалдаа зэрэг үйлчлүүлэгчтэй шууд нүүр тулж харьцдаггүй үйлчилгээний хэлбэрт шилжсэн жижиг хэмжээний худалдаа эрхлэгч

Дээр дурьдсан үйлчилгээний хэлбэрт шилжихийн тулд тоног төхөөрөмж болон системд хөрөнгө оруулалт хийсэн байх шаардлагатай

Зээл болон татвар

## Хувь хүнд зориулсан бага хэмжээний яаралтай зээл (онцгой арга хэмжээ)



Бага сургууль түр хаагдах болон хувиараа аж ахуй эрхлэгч  
**200,000 хүртэл иэн дотор**  
 Бусад тохиолдолд  
**100,000 хүртэл иэн дотор**

## Харилцах цонх


Нийгмийн халамжийн зөвлөл (мөн нэмэлтээр Хөдөлмөрийн Банк)

### Болзол

Шинэ төрлийн Корона вирусын улмаас орлого буурсан, амжиргааны зардлаа хангах шаардлагатай байгаа хүн

Хүүгүй/Барьцаагүй/ Зээлийн эргүүлэн төлөлтийг хойшлуулах хугацаа 1 жил/ Зээл төлөх хугацаа 2 жил

## Санхүүгийн тусламж бүхий аливаа төрлийн зээл



**Орлогын хэмжээний бууралтаас** шалтгаалж зээлийн төрөл болон харилцах цонх өөр өөр байх боловч **барьцааны төлбөргүй, хүүгүй, зээлийн төлөлтийн хойшлуулах хугацаатай зээл** олгогдох боломжтой.

## Харилцах цонх


Зүүн талд байгаа QR кодыг уншуулж шалгана уу (Эдийн засаг, худалдаа, үйлдвэрлэлийн яамнаас боловсруулсан лист)

### Болзол

Корона вирусын улмаас орлого буурсан, санхүүгийн хувьд хүнд байдалд орсон аж ахуй эрхлэгч


Японы санхүүгийн корпораци, Shoko Chukin банк (商工中金), хувийн хэвшил зэрэг

## Татвартай холбоотой дэмжлэгийн арга хэмжээнүүд



Улсын болон орон нутгийн татварын төлөлтийг 1 жилээр хойшлуулах, үндсэн хөрөнгийн татварын хэмжээг бууруулах арга хэмжээтэй холбоотой мэдээллийг **TKC-н албан ёсны вэб хуудсаас (QR код)** шалгана уу

## Аймаг, орон нутаг болон хот, дүүрэг, суурингаас үзүүлэх дэмжлэг



Нутгийн өөрөө удирдах байгууллагаас зохион байгуулж буй дэмжлэгийн талаарх мэдээллийг **TKC-н вэб хуудас (QR код)** руу ороод холбогдох аймаг, орон нутгаа сонгож хайх боломжтой.